



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2020 оны 11 дүгээр  
сарын 3-ны өдөр

Дугаар 79

Улаанбаатар  
хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

а) Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (төлөвлөлт, хөрөнгө оруулалтын алба, удирдлага, төлөөллийн албатай);


б) Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс;

в) Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс;

г) Захиргаа, удирдлагын хэлтэс (мэдээлэл, технологийн албатай);

д) Хууль, эрх зүйн хэлтэс.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” Ерөнхий сайдын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 6 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

*Хандогддог бүтцийн хөтөлбөр*  
*Бүтцийн хөтөлбөр*  
*Хөтөлбөрийн хөтөлбөр*  
*Хөтөлбөрийн хөтөлбөр*  
11/06/2020

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН  
БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (цаашид "Агентлаг" гэх)-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид "хөтөлбөр" гэх)-ийн зорилго нь төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг хариуцах, бүртгэлээр хяналт тавих, төрийн өмчит хуулийн этгээдэд компанийн сайн засаглалыг нэвтрүүлэх, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх, стратеги төлөвлөгөөг батлах, төрийн өмчийг хувьчлах, хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах, төрийн өмчийн улсын үзлэг, тооллого хийх, орон нутгийн өмчийн асуудлаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах хүрээнд агентлагийн үйл ажиллагааны стратеги болон зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлоход оршино.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого", Улсын Их Хурлын 2020 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" 7 дугаар тогтоолыг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн орчин

- Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:
- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Компанийн тухай хууль;
- Орон сууц хувьчлах тухай хууль;

- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Иргэний хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого; холбогдох бусад хууль тогтоомж.

#### 1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн ерөнхий загвар”, өмнөх жилүүдэд Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги боловсруулж хэрэглэсэн болон энэ талаарх олон улсын болон дотоодын туршлага, арга зүй, мэдээллийг ашиглав.

#### 1.5. Агентлагийн үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Агентлаг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Орон сууц хувьчлах тухай хуульд заасан бүрэн эрх, чиг үүргийг хариуцаж, энэ талаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн тухайн жилийн төлөвлөгөө, бусад бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлж, Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Ерөнхий сайдыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах үүргийг хүлээнэ.

Агентлаг нь төрийн өөрийн өмчийн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд холбогдох салбарын бодлого, төлөвлөлт болон төсвийн зарцуулалтын тэнцвэртэй байдал, харилцан уялдаа холбоог ханган ажиллаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

#### 1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч

Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч хамрагдана.

## Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр



Агентлагийн стратегийн удирдлагыг дээр дурдсан үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээг хангах, үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоож, тус агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

### Хоёр. Агентлагийн үйл ажиллагааны стратеги

#### 2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын талаарх холбогдох хууль тогтоомж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн тухайн жилийн төлөвлөгөө, бусад бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Ерөнхий сайдад мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хууль тогтоомжийн хүрээнд удирдлага, зохицуулалтаар хангах, иргэн, хуулийн этгээдэд төрийн өмчийн харилцааны болон хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээнд хамаарах асуудлаар мэдээлэл өгч, үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэнэ.

#### 2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Агентлаг нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1. төрийн өмчийн бодлого, зохицуулалтыг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх;

2.2.2. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд компанийн сайн засаглалыг нэвтрүүлэх, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх;

2.2.3. төрийн өмчит хуулийн этгээдийг үр ашигтай арга, хэлбэрийг ашиглан өөрчлөн байгуулах, хувьчлах, шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах замаар төрийн өмчийн өгөөжийг нэмэгдүүлэх;

2.2.4. төрийн өмчит компаниудаас нэмэлт хувьцаа гаргаж нийтэд санал болгох (IPO хийх), хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулж, үр ашгийг нэмэгдүүлэх;

2.2.5. төрийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, бүртгэлээр хяналт тавих, өмчийн улсын үзлэг, тооллогыг зохион байгуулах, төрийн өмчийн ашиглалт, зохицуулалтад гүйцэтгэлийн болон баримтын хяналт шалгалт хийх, үр ашигт дүн шинжилгээ хийх;

2.2.6. нээлттэй, ил тод, шуурхай, чанартай, хүртээмжтэй үйлчилгээг иргэд, хуулийн этгээдэд үзүүлэх.

### 2.3. Эрхэм зорилго

Агентлагийн эрхэм зорилго нь төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтад хяналт тавих, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх, удирдлага, менежментийг боловсронгуй болгох замаар төрийн өмчийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэхэд оршино.

### 2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Агентлаг нь дээрх эрхэм зорилгод хүрэхийн тулд үйл ажиллагааны дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

2.4.1. төрийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах удирдлага, зохицуулалтаар хангах, төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн санхүү, хөрөнгө оруулалт, зорилтот түвшинд шинжилгээ хийх, хянан батлах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх;

2.4.2. төрийн өмчийг эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдалд бүртгэлээр хяналт тавьж, төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх;

2.4.3. төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтад тавих төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, төрийн өмчийн үр ашиг, төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх;

2.4.4. захиргаа, хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, бүтцийн нэгж хоорондын уялдаа холбоог сайжруулах, албан хаагчдын хөдөлмөр, нийгмийн харилцааны асуудлыг шийдвэрлэх, чадавхыг дээшлүүлэх, хэвлэл, олон нийттэй харилцах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;

2.4.5. агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд гарах захиргааны шийдвэрийг хянах, шинжлэн судлах, хууль зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх, зохион байгуулалтын нэгж болон хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллах, агентлагийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах.

## 2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлнэ:

### 2.5.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1. төрийн болон орон нутгийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, тогтоол шийдвэрийн төсөл боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.5.1.2. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг сайжруулах, бүтцийн өөрчлөлт хийх, хувьчлах замаар үр ашгийг дээшлүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан зохион байгуулах;

2.5.1.3. төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн санхүү, хөрөнгө оруулалт, зорилтот түвшинд шинжилгээ хийх, хянан батлах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх;

2.5.1.4. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, улсын үйлдвэрийн газрыг үр ашигтай ажиллуулах, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, нэмэлт хөрөнгө оруулалт татах, зорилтот түвшин, ашиг, орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох замаар төрийн хувьцаа эзэмшигч болон улсын төсвийн өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах;

2.5.1.5. аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад орон нутгийн өмчийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

### 2.5.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1. төрийн өмчийн улсын нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах;

2.5.2.2. төрийн өмчөөс орон нутгийн өмчлөлд, орон нутгийн өмчлөлөөс төрийн өмчлөлд шилжүүлэх эд хөрөнгийн асуудлыг судлан, санал боловсруулж шийдвэрлүүлэх;

2.5.2.3. төрийн өмчийн үзлэг, тооллогыг улсын хэмжээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, нэгтгэн тайлагнах;

2.5.2.4. төрийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг түрээслүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг данснаас хасах (худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах), шинээр авах харилцааг хариуцан

зохион байгуулж, удирдлага, иргэн, хуулийн этгээдэд мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

2.5.2.5. төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэх, дүн мэдээ гаргах.

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1. төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад хяналт шалгалт хийх, зөрчил, доголдлыг арилгуулах;

2.5.3.2. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн болон санхүүгийн үйл ажиллагаанд баримтын хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулж хэвшүүлэх;

2.5.3.3. шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдалд мониторингийн хяналт тавих;

2.5.3.4. төрийн өмчийн үр ашгийн байдалд судалгаа, дүгнэлт хийж, төсвийн сахилга батыг хэвшүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах.

2.5.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1. хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, агентлагийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах замаар захиргааны удирдлагын манлайллыг хангах;

2.5.4.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын болон даргын дэргэдэх Зөвлөлийн хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хариуцаж, агентлагийн дарга, орон тооны бус гишүүд, албан хаагчдад дэмжлэг үзүүлэх;

2.5.4.3. хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах;

2.5.4.4. байгууллага, нэгж, албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэл, бодлого, шийдвэрийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэх;

2.5.4.5. байгууллагын үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөх, төсөв, санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангаж, үр ашигтай зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

2.5.4.6. мэдээллийн технологид суурилсан үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэх.

2.5.5. Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.5.5.1. хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, төсөл боловсруулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.5.5.2. хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах;

2.5.5.3. захиргааны шийдвэр, албан бичгийн эрх зүйн үндэслэлийг хянаж, хууль тогтоомжид нийцүүлэх, төрийн өмчийн болон бусад асуудлаар хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

2.5.5.4. хууль, хяналтын байгууллагад хянагдаж байгаа хэрэг, маргааны шийдвэрлэлтэд агентлагийг төлөөлж, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.

## 2.6. Үйл ажиллагааны зорилт

Агентлагийн үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

## 2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:



## Үйл ажиллагааны стратегийн загвар

Эрхэм зорилго	Үйл ажиллагааны стратегийн зорилт	Үйл ажиллагааны гол зорилт
Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтад хяналт тавих, төрийн өмчт болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх, удирдлага, менежментийг боловсронгуй болгох замаар төрийн өмчийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэхэд оршино.	Төрийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах удирдлага, зохицуулалтаар хангах, төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн санхүү, хөрөнгө оруулалт, зорилтот түвшинд шинжилгээ хийх, хянан батлах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>-төрийн болон орон нутгийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, тогтоол шийдвэрийн төсөл боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;</li> <li>-төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг сайжруулах, бүтцийн өөрчлөлт хийх, хувьчлах замаар үр ашгийг дээшлүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан зохион байгуулах,</li> <li>-төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн санхүү, хөрөнгө оруулалт, зорилтот түвшинд шинжилгээ хийх, хянан батлах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх;</li> <li>-төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, улсын үйлдвэрийн газрыг үр ашигтай ажиллуулах, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, нэмэлт хөрөнгө оруулалт татах, зорилтот түвшин, ашиг, орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох замаар төрийн хувьцаа эзэмшигч болон улсын төсвийн өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах;</li> <li>-аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад орон нутгийн өмчийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.</li> </ul>
	Төрийн өмчийг эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдалд бүртгэлээр хяналт тавьж, төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>-төрийн өмчийн улсын нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах;</li> <li>-төрийн өмчөөс орон нутгийн өмчлөлд, орон нутгийн өмчлөлөөс төрийн өмчлөлд шилжүүлэх эд хөрөнгийн асуудлыг судлан, санал боловсруулж шийдвэрлүүлэх;</li> <li>-төрийн өмчийн үзлэг, тооллогыг улсын хэмжээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, нэгтгэн тайлагнах;</li> <li>-төрийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг түрээслүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг данснаас хасах (худалдах, шилжүүлэх, акт тогтоон усгах), шинээр авах харилцааг хариуцан зохион байгуулж, удирдлага, иргэн, хуулийн этгээдэд мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;</li> <li>-төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэх, дүн мэдээ гаргах.</li> </ul>
	Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтад тавих төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, төрийн өмчийн үр ашиг, төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>-төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад хяналт шалгалт хийх, зөрчил, доголдлыг арилгуулах;</li> <li>-төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн болон санхүүгийн үйл ажиллагаанд баримтын хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг бүрэн аригдуулж хэвшүүлэх;</li> <li>-шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдалд мониторингийн хяналт тавих;</li> <li>-төрийн өмчийн үр ашгийн байдалд судалгаа, дүгнэлт хийж, төсвийн сахилга батыг хэвшүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах.</li> </ul>
	Захиргаа, хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, бүтцийн нэгж хоорондын уялдаа холбоог сайжруулах, албан хаагчдын хөдөлмөр, нийгмийн харилцааны асуудлыг шийдвэрлэх, чадавхыг дээшлүүлэх, хэвлэл, олон нийттэй харилцах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>-хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, агентлагийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах замаар захиргааны удирдлагын манлайллыг хангах;</li> <li>-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын болон даргын дэргэдэх Зөвлөлийн хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хариуцаж, агентлагийн дарга, орон тооны бус гишүүд, албан хаагчдад дэмжлэг үзүүлэх;</li> <li>-хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах;</li> <li>-байгууллага, нэгж, албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэл, бодлого, шийдвэрийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэх;</li> <li>-байгууллагын үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөх, төсөв, санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангаж, үр ашигтай зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;</li> <li>-мэдээллийн технологид суурилсан үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэх.</li> </ul>
	Агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд гарах захиргааны шийдвэрийг хянах, шинжлэн судлах, хууль зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх, зохион байгуулалтын нэгж болон хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллах, агентлагийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах	<ul style="list-style-type: none"> <li>-хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, төсөл боловсруулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;</li> <li>-хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах;</li> <li>-захиргааны шийдвэр, албан бичгийн эрх зүйн үндэслэлийг хянаж, хууль тогтоомжид нийцүүлэх, төрийн өмчийн болон бусад асуудлаар хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;</li> <li>-хууль, хяналтын байгууллагад хянагдаж байгаа хэрэг, маргааны шийдвэрлэлтэд агентлагийг төлөөлж, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.</li> </ul>

## 2.8. Гүйцэтгэлийн төлөвлөгөө

Агентлаг нь өөрийн эрхэм зорилго, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллана. Агентлагийн гүйцэтгэлийн төлөвлөгөө нь төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулах гэрээний салшгүй хэсэг байна.

Гурав. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

### 3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим


Агентлагийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

- 3.1.1. Агентлагийн стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх;
- 3.1.2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх;
- 3.1.3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх;
- 3.1.4. Бүтцийн хувьд энгийн байх;
- 3.1.5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоосон байх;
- 3.1.6. Үйл ажиллагааны давхардалгүй байх;
- 3.1.7. Улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх;
- 3.1.8. Хангалттай чадавхтай байх;
- 3.1.9. Үйл ажиллагаа бодитой байх.

### 3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг дор дурдсанаар тодорхойлж байна.

### Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



#### 3.3. Агентлагийн удирдлага

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дарга, орон тооны бус 8 гишүүнээс бүрдэнэ. Агентлаг нь дэд даргатай байна. Агентлагийн даргын дэргэд төрийн өмчийн асуудлаар Зөвлөл байгуулан ажиллана.

#### 3.4. Зохион байгуулалтын бүтэц

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг тус тус үндэслэн агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгж, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг дараахь байдлаар тодорхойлж байна.

3.4.1. Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд төрийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, удирдлага, зохицуулалтаар хангах, төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн санхүү, хөрөнгө оруулалт, зорилтот түвшинд шинжилгээ хийх, хянан батлах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн үүрэг хүлээж, төрийн болон орон нутгийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого,

чиглэл, тогтоол шийдвэрийн төсөл боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах; төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн санхүү, хөрөнгө оруулалт, зорилтот түвшинд шинжилгээ хийх, хянан батлах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх; төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг сайжруулах, бүтцийн өөрчлөлт хийх, хувьчлах замаар үр ашгийг дээшлүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан зохион байгуулах; төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, улсын үйлдвэрийн газрыг үр ашигтай ажиллуулах, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, нэмэлт хөрөнгө оруулалт татах, зорилтот түвшин, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох замаар төрийн хувьцаа эзэмшигч болон улсын төсвийн өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах; төрийн өмчийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилт, хуулийн этгээдийн удирдлагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийж, шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээ авах; аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад орон нутгийн өмчийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөлт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж, удирдлага, төлөөллийн асуудал хариуцсан нэгж тус тус ажиллана.

Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалт, зорилтот түвшин, үйлдвэрлэл, техник технологи, хүний нөөцийн төлөв байдалд судалгаа, шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгч, төлөвлөлт, хуваарилалт, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ажиллана.

Удирдлага, төлөөллийн асуудал хариуцсан нэгж нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн төлөөлөл, компанийн засаглалыг хэрэгжүүлэх, төлөөлөн удирдах зөвлөлийг нэгдсэн удирдлагаар хангах, төрийн өмчит хуулийн этгээдийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчийн хувьцааг худалдах шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах, орон нутгийн өмчийг удирдах ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан нэгж нь чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийг нэгдсэн удирдлагаар хангах, төрийн өмчийн төлөөлөл, компанийн засаглалыг хэрэгжүүлэх, төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, хөрөнгийн өгөөж, үр ашгийг нэмэгдүүлэх талаар бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах; төрийн өмчийн төлөөлөгчийг томилох, чөлөөлөх, урамшуулах, хариуцлага тооцох санал, хуулийн этгээдийн дүрэм, бизнес төлөвлөгөө, зохион байгуулалтын бүтэц, цалин хөлсний норм, норматив, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний төслийг боловсруулах, хянах, хуралд оруулан шийдвэрлүүлэх, хамтарсан үйлдвэрүүдийн талаар Засгийн газраас баримталж буй бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, төрийн өмчийн талаарх Засгийн газар хоорондын хэлэлцээр, үүсгэн байгуулагчдын гэрээ, дүрмийн төслийг боловсруулах, төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийн орлогын төлөвлөгөөний төслийг батлуулан биелэлтийг хангуулж ажиллах, алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит хуулийн этгээдийн бүтээгдэхүүний үнэ тарифын зохицуулалтын талаар холбогдох байгууллагуудтай хамтарч санал боловсруулах, батлуулах, хуулийн этгээдийн үйлдвэрлэл, техник, технологи, санхүү, эдийн засаг, хүний

нөөцийн төлөв байдал, чиг хандлагад судалгаа, шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгч шаардлагатай арга хэмжээ авах; төлөвлөлт, хөрөнгө оруулалтыг хянан батлах, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх; төрийн өмчийн компаниудаас нэмэлт хувьцаа гаргаж нийтэд санал болгох (IPO хийх), хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг шинэчлэх, олон улсын жишигт хүргэх, төрийн өмчит компаниудын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлийг бий болгох, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, хувьчлах төслийг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулан хэрэгжилтийг хангах, хувьчлах орон нутгийн өмчийн эд хөрөнгийн жагсаалтыг хянах, хуралдаанд оруулан зөвшилцөх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь агентлагийн дарга байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн орон тооны бус гишүүд, зохион байгуулалтын бүтцийн нэгж, ажилтнууд, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, бусад байгууллага, аж ахуйн нэгж байна. Энэ нэгжийн гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Үндэсний статистикийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Татварын ерөнхий газар, аймаг, нийслэлийн удирдлага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд, бусад холбогдох байгууллага байна.

3.4.2. Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хамгаалалт, захиран зарцуулалттай холбоотой бүртгэл, зохион байгуулалт хийх, үзлэг тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдалд бүртгэлээр хяналт тавьж, төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх үндсэн үүрэг хүлээж, төрийн өмчийн улсын нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, бүртгэлээр хяналт тавих; төрийн өмчөөс орон нутгийн өмчлөлд, орон нутгийн өмчлөлөөс төрийн өмчлөлд шилжүүлэх эд хөрөнгийг судлан санал боловсруулж шийдвэрлүүлэх; төрийн өмчийн үзлэг тооллогыг улсын хэмжээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, нэгтгэн тайлагнах; төрийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг түрээслүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг данснаас хасах (худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах), шинээр авах харилцааг хариуцан зохион байгуулж, удирдлага, иргэн, хуулийн этгээдэд мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх; төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэх, дүн мэдээ гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь холбогдох бодлого, шийдвэр, журам, зааврыг мөрдүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа барилга, байгууламж, эд хөрөнгийн ашиглалт, захиран зарцуулалтад өмч эзэмшлийн гэрээ байгуулан бүртгэлээр хяналт тавих, төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах, олж авах саналыг хянаж шийдвэрлүүлэх, хөрөнгийн хөдлөлийг бүртгэлд тусгуулах, төрийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг түрээслүүлэх журам, түрээсийн төлбөрийг зах зээлийн үнэд нийцүүлэн нутаг дэвсгэрээр бүсчлэн тогтоож, түүний биелэлтэд хяналт тавих, орон нутгийн өмчийн нэгж, мэргэжилтнүүдэд өмчийн бүртгэл, мэдээлэл, мониторингийн асуудлаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхэд чиглэнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь агентлагийн дарга байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн орон тооны бус гишүүд, зохион байгуулалтын бүтцийн нэгж, ажилтнууд, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, бусад аж ахуйн нэгж, байгууллага байна.

Энэ нэгжийн гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аудитын газар, Сангийн яам, Үндэсний статистикийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Татварын ерөнхий газар, орон нутгийн өмчийн байгууллагууд, төсөвт байгууллагууд, арилжааны банкууд, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, улсын үйлдвэрийн газрууд, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд, бусад холбогдох байгууллага байна.

3.4.3. Төрийн өмчийн хяналт шалгалт хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтад тавих төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, төрийн өмчийн үр ашиг, төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх үндсэн үүрэг хүлээж, төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад хяналт шалгалт хийх, зөрчил, доголдлыг арилгуулах; төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн болон санхүүгийн үйл ажиллагаанд баримтын хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулж хэвшүүлэх; шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдалд мониторингийн хяналт тавих; төрийн өмчийн үр ашгийн байдалд судалгаа, дүгнэлт хийж, төсвийн сахилга батыг хэвшүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил доголдлын шалтгааныг тогтоох, арилгуулах арга хэмжээ авах, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний талаар санал боловсруулах, зөрчлийн болон өмчийн үр ашгийн талаарх судалгаа, мэдээ гаргах, дүгнэлт анализ хийх, төсвийн сахилга, хариуцлага, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр холбогдох санал, төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх, гаргасан зөрчилд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах арга хэмжээ авах, хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтэд мониторинг хийх, эрх бүхий байгууллагын захиалгаар магадлан шалгалт хийхэд чиглэнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь агентлагийн дарга байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн орон тооны бус гишүүд, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн ажилтнууд, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, бусад аж ахуйн нэгж, байгууллага байна. Энэ нэгжийн гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аудитын газар, Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Татварын ерөнхий газар, Прокурорын байгууллага, орон нутгийн өмчийн байгууллага, төсөвт байгууллагууд, арилжааны банкууд, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, улсын үйлдвэрийн газрууд, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд, холбогдох бусад байгууллага байна.

#### 3.4.4. Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд захиргаа, хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, бүтцийн нэгж хоорондын уялдаа холбоог сайжруулах, албан хаагчдын хөдөлмөр, нийгмийн харилцааны асуудлыг шийдвэрлэх, чадавхыг дээшлүүлэх, хэвлэл, олон нийттэй харилцах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх үндсэн үүрэг хүлээж, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, агентлагийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах замаар захиргааны удирдлагын манлайллыг хангах; Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын болон даргын дэргэдэх Зөвлөлийн хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хариуцаж, агентлагийн дарга, орон тооны бус гишүүд, албан хаагчдад дэмжлэг үзүүлэх; хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах; байгууллага, нэгж, албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэл, бодлого, шийдвэрийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэх; байгууллагын үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөх, төсөв, санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангаж, үр ашигтай зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх; мэдээллийн технологид суурилсан үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь агентлагийн үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, дотоодод хэрэгжих холбогдох дүрэм, журам, заавар, гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, нэгж, албан хаагчдын гүйцэтгэлийг төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих; тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангуулах, нэгтгэн тайлагнах; төрийн албаны хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах, албан хаагчдын хөдөлмөр, нийгмийн харилцаа, сургалтын асуудлыг шийдвэрлэх; авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулж, тайлагнах, албан хаагчдад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх; төрийн болон албаны нууцын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нууцын хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах, хяналт тавих; хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг хэрэгжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бий болгох; Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын болон даргын дэргэдэх Зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, түүний шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих; агентлагийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, бэхжүүлэх; хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах; архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг эрхлэх, иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, холбогдох нэгжээр шийдвэрлүүлэх; агентлагийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, удирдлагын шийдвэр гаргахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь чадварлаг төрийн албан хаагч бүхий мэргэшсэн албыг бүрдүүлж, агентлагийн тасралтгүй, хэвийн, жигд үйл ажиллагааг хангах; төрийн албан хаагчдыг мэргэшүүлж, хөгжүүлэх, тэдний үйл ажиллагааны гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх, тайлагнах; байгууллага, нэгж, албан хаагчдын гүйцэтгэл, бодлого, шийдвэрийн хэрэгжилт, үр дагаварт хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудит хийж, үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах; зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн санал, зөвлөгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд мэдээлэл, технологийн асуудал хариуцсан нэгж ажиллана. Мэдээлэл, технологийн асуудал хариуцсан нэгж нь байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй сурталчлах, иргэд, олон нийттэй харилцах; байгууллагын техник, програм хангамжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, холбогдох санал боловсруулах, шийдвэрлүүлэх; програм хангамж, цахим систем, интернетийн сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангах, шаардлагатай засвар, үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлтийг тухай бүр хийх; цахим систем, байгууллагын цахим хуудсыг хөгжүүлэх; агентлагт ашиглагдаж байгаа мэдээллийн системүүдийг нэгдсэн стандарт, удирдлагаар хангаж, түүний шинэчлэлт болон мэдээллийн урсгалд хяналт тавих, боловсронгуй болгох; мэдээллийн технологийн ололтыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, мэдээллийн технологид суурилсан цахим шийдлүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх; мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь агентлагийн дарга, орон тооны бус гишүүд, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, орон нутгийн өмчийн байгууллага байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, иргэд, хуулийн этгээд байна. Энэ бүтцийн нэгжийн гол түнш нь төрийн захиргааны төв байгууллага, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний дата төв, орон нутгийн өмчийн нэгжүүд, арилжааны банкууд, холбогдох бусад байгууллага, хуулийн этгээд, иргэн байна.

3.4.5. Хууль, эрх зүйн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд гарах захиргааны шийдвэрийг хянах, шинжлэн судлах, хууль зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх, зохион байгуулалтын нэгж болон хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллах, агентлагийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах үндсэн үүрэг хүлээж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, төсөл боловсруулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх; хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах; захиргааны шийдвэр, албан бичгийн эрх зүйн үндэслэлийг хянаж, хууль тогтоомжид нийцүүлэх, төрийн өмчийн болон бусад асуудлаар хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх; хууль, хяналтын байгууллагад хянагдаж байгаа хэрэг, маргааны шийдвэрлэлтэд агентлагийг төлөөлж, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь захиргааны акт, дүрэм, журам, зааврыг боловсруулах, энэ талаар албан хаагчдад дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, хянах, хамтран ажиллах, хэрэгжилтэд хяналт тавих, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах; хууль, хяналтын байгууллагад агентлагийг төлөөлөх, хариу тайлбар, нэхэмжлэл гаргах, боловсруулах, хянах, батлуулах, нотлох баримт гаргуулах; агентлагийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж болон хэрэг, маргаануудын хууль эрх зүйн үндэслэлийг шинжлэн судлах; хууль тогтоомжийг сурталчлан таниулах, удирдлага болон албан хаагчдад хууль зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, зохион байгуулалтын бүтцийн нэгж болон хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллахад чиглэнэ.



Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааг хууль, эрх зүйн хүрээнд тасралтгүй, хэвийн байдлыг хангахад чиглэх бөгөөд эрх зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, захиргааны эрх зүйн баримт бичгийг хянах, энэ талаар байгууллагыг төлөөлөх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь агентлагийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, төрийн өмчит хуулийн этгээд байна. Энэ нэгжийн гол түнш нь төрийн захиргааны төв байгууллага, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газар, бүх шатны шүүх, холбогдох бусад байгууллага, хуулийн этгээд, иргэн байна.

----oO----

THE UNIVERSITY OF  
MICHIGAN LIBRARY

YFAC013

7388

8/109

18x